Батлав. Дархан-Уул Аймгийн Ерөнхий архитекторын
үүргийг түр орлон гүйцэтгэгч . . . . . /Х.Олонбаяр/

Архитектур төлөвлөлтийн даалгавар
Дугаар 21/48

Огноо 2021.08.03 Дархан

1	Барилга байгууламжийн байршил тогтоосон газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрын байршил, хэмжээ.	Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг даргын 2021 оны 6-р сарын 30-ны өдрийн А/67 тоот захирамж төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газар. **Газрын байршил:** Дархан сум, 3-р баг, Улаан толгойн 1-р гудамж145 тоот **Газрын хэмжээ:** 9282 м^2 **Зориулалт:** " Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар"
2	Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал.	Үйлдвэрлэлийн барилга
3	Барилгын хэмжээ.	Барилгын хэмжээг тухайн газрын байдалд тохируулан технологийн шаардлагын дагуу барилгын зураг төсөл зохиогч шийдвэрлэнэ.
4	Барилгын төрөл, давхрын тоо. -дээд хязгаар -доод хязгаар	Технологийн шаардлагын дагуу төлөвлөх
5	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө.	Дархан хотын Ерөнхий төлөвлөгөө
6	Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл.	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний умард бүс
7	Эдэлбэр газрын хэмжээ.	9282 м^2
	Үүнээс: -барилгажих талбай	Технологийн шаардлагын дагуу төлөвлөх
	-Ногоон байгууламжийн талбай	
	-Авто зогсоол, зам талбай	
	-Бусад	-
8	Барилгажилтын улаан шугамын зай.	-Хорооллын доторх болон төлөвлөлтөнд тусгагдсан автозамаас 6 метрээс багагүй зайд төлөвлөх. -Хотын төв автозамаас 15 метрээс багагүй зайд төлөвлөх. -Барилга хоорондын зай, шугаман байгууламжийн тусгаарлах зурвасуудыг норм дүрмийн дагуу төлөвлөх. - Барилга угсралтын ажил эхлүүлэхийн өмнө барилгын улаан шугамыг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар тавиулж ГХБХБГазраар хянуулсны дараа газар шорооны ажлыг эхлүүлэх.
9	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтонд тавигдах шаардлага.	- Орчны барилга байгууламжуудтай уялдуулж төлөвлөх. - Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж хотын авто замын сүлжээнд холбогдохоор төлөвлөлтийн шийдлийг боловсруулах. - Олгогдсон газарт ИШС байрлаж байгаа тохиолдолд түүний тусгаарлах зурваст барилга байгууламж төлөвлөхгүй байх.

		-Галын аюулгүй байдлыг хангахтай холбоотой зай хэмжээ, норм дүрмийг төлөвлөлтөд баримтлах.
10	Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага.	Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилгуудтай уялдуулж талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх.
11	Архитектур төлөвлөлтийн шаардлага.	- **Газар хөдлөлтийн 7-8 баллын бүсэд хамаарагдана.** Архитектур төлөвлөлтөнд онцгой анхаарч, барилга хоорондын зай, барилгын фасад, архитектурын шийдлийг хажуугийн барилгууд болон орчинтой зохицуулан, тухайн орчны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийж батлуулан, төлөвлөлтийг уялдуулан гүйцэтгэх Тухайн орчны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийж батлуулан, төлөвлөлтийг уялдуулан гүйцэтгэх. **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц гарц, тээврийн хэрэгслийн зогсоол төлөвлөх.**
12	Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага.	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдохоор өгөгдсөн техникийн нөхцөлийн шаардлагыг хангах.
13	Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл.	-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх. -Тухайн газарт эрүүл ахуйн улсын байцаагчийн шаардлагатай дүгнэлт гаргуулах. -Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэж ажлын зураг хийхэд хөрсний бүтцээс хамаарсан, хөрсний шилжилтийг тооцож газар шорооны ажил эхлэх, газар доорхи болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр ажлын зургийг боловсруулан батлуулж газар шорооны ажил эхлэх. - Гадна тохижилт, зам талбайд гэрэлтүүлэг хийж тохижуулах, зөвшөөрөлгүй хашаа хайс барьж архитектур, хот байгуулалтын орон зайг алдагдуулахыг хориглох ба авто зам болон явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар төлөвлөлтийг боловсруулах.
14	Инженерийн бэлтгэл арга хэмжээ /үерийн хамгаалалт, далан суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ/.	- Талбайн зохион байгуулалтын төсөл болон ажил гүйцэтгэх төслийг хийж батлуулах.
15	Захиалагчийн нэр, хаяг, утас.	Утас:

Боловсруулсан:
ГХБХБГ-ын мэргэжилтэн. . . . . /С.Дарханбаатар/